



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/24

Хажуу шинэ-Ус

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралт "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6.16, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 07 дугаар тогтоол "Дундговьго ногооруулъя" дэд хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.1, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг суманд хэрэгжүүлэх, хамтран ажиллах аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нарын 2022 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн 22-02 дугаар гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.10, Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 5.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эх дэлхийг аваръя жиргээ холбоо" НҮТББ-тай ӨМӨЗО-ны Ордос хотод "Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах туршлага судлах сургалт" зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу сургалтад оролцох иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. ӨМӨЗО-ны Ордос хотод туршлага судлах сургалтад хамрагдах иргэдэд сумын хэмжээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хүнсний ногоо тариалагч нарт туршлага түгээх ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосугай.

3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 10,000,000.00 (Арван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах сангаас гарган зарцуулахыг Санхүү албаны дарга (Н.Ганбат), Сан, соёлын төв хариуцсан нягтлан бодогч (Э.Уранбилэг) нарт зөвшөөрсүгэй.

Хавсралт .....хуудаастай.

ЗАСАГ ДАРГА



ТАРИУНАА

482301024